



СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2014 оны 03 сарын 19 өдөр

Дугаар 24


Сүхбаатар

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. "Цахим сургууль-цахим сургалт" аймгийн хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар ханган, сумдын шилэн кабелийг ашиглалтанд оруулж хэрэглэгчдэд хүргэх ажлыг 2014-2015 онд багтаан зохион байгуулж, хөтөлбөрийн биелэлтийн явцыг жил бүр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулж байхыг аймгийн Засаг дарга /С.Бүрэнбат/-д даалгасугай.

ДАРГА  Ж.САНЖЖАВ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2014 оны 03 дугаар сарын 19-ний  
өдрийн 24 дугаар тогтоолын хавсралт

## “ЦАХИМ СУРГУУЛЬ-ЦАХИМ СУРГАЛТ” АЙМГИЙН ХӨТӨЛБӨР

### Нэг. Үндэслэл

Аливаа улс орны хөгжлийн түлхүүр нь хүний хөгжилдөө оршдог. Тиймээс хүнээ хөгжүүлэхийн тулд боловсролын системээ шинэчилж, чанартай боловсрол олгох, сүүлийн үеийн дэвшилтэт технологи бүхий сургалтын орчинд сургах, хүүхэд, багш бүрийг компьютертой болгох, компьютерийн мэдлэг, дадлага эзэмшүүлэх боломжоор хангах, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааг мэдээллийн технологийн тусламжтайгаар шинэ түвшинд гаргах зайлшгүй шаардлага бий болж байна.

Боловсролын салбарт мэдээлэл, харилцаа холбооны технологийг нэвтрүүлэх талаар “Бага, дунд боловсролын салбарт 2015 он хүртэлх хугацаанд мэдээллийн технологийг нэвтрүүлэх үндсэн чиглэл”, Боловсролын салбарт мэдээлэл, харилцаа холбооны технолог (МХХТ)-ийг баримтлах бодлого (2012-2016 он) зэрэг баримт бичиг боловсруулж хэрэгжүүлснээр тодорхой үр дүнд хүрсэн.

Эдгээр бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сургуулиудыг өндөр хурдны шилэн кабелийн сүлжээгээр интернетэд холбох ажлыг үе шаттайгаар шийдвэрлэх, албан бус сургалтаар зайны сургалтыг хөгжүүлэх, сургалтын стандарт, хөтөлбөрийг цахим хэлбэрт оруулах, багш нарын мэдээлэл, харилцаа холбооны технологийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зэрэг ажил хийгдэж байна.

Багш, сурагчид МХХТ-ийг идэвхтэй ашиглах хандлага бий болж, сургууль бүр тодорхой түвшинд дэд бүтэц, техник хэрэгслээр хангагдсан боловч хүүхэд хөгжүүлэх сургалтын цахим хэрэглэгдэхүүнийг тасралтгүй боловсруулж ашигладаг тогтолцоо бүрдүүлэх, багш ажлын байрандаа бие дааж өөрийгөө хөгжүүлэх, сургалтыг зайны онлайн хэлбэрээр явуулах, багш-сурагч-эцэг эх хоорондын мэдээллийн харилцаа, хамтын ажиллагааг дэмжих, багш, ажилтны өдөр тутмын үйл ажиллагааг хөнгөвчлөх, бүх шатны удирдах ажилтан төлөвлөлт хийх, шийдвэр гаргахдаа ашигладаг нэгдсэн мэдээллийн системийг бий болгох, сургуулийн техник хэрэгслийг үе шаттай шинэчлэх, засвар үйлчилгээ хийх асуудал орхигдож, интернэтийн хурд удаан, интернэтийн төлбөрийг төсөвт тусгадаггүй зэрэг тулгамдсан асуудал хэвээр байна.

2013-2014 оны хичээлийн жилийн судалгаагаар Сэлэнгэ аймгийн ерөнхий боловсролын 35 сургуулийн 17502 суралцагч мэдээлэл зүйн танхимаар 612 компьютер, 964 багш 393 компьютер, 28 электрон самбар, 101 проектор сургалтандаа хэрэглэж, нэг компьютерт ногдох хүүхдийн тоо дунджаар 29, багшийн тоо дунджаар 3 байгаа нь хангалтгүй үзүүлэлт юм.

БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 2013 оны жилийн эцсийн байдлаар шилэн кабелиар 9 сургууль, VISAT-аар 3 сургууль интернэтэд холбогдон сургалтын үйл ажиллагаагаа зохион

байгуулж байгаа ба 23 ерөнхий боловсролын сургууль өөрийн нөөц бололцоог ашиглан үүрэн холбооны операторын модем ашиглаж интернетийн хэрэглээгээ авч байна.

Мэдээлэл харилцааны эрин зуунд манай хүүхдүүд бусад орны үе тэнгийнхнээс хоцролгүй мэдээлэл авах, мэдээлэлтэй харилцах арга ухаанд суралцах шаардлагатай гарч байна. Иймд тэднийг бэлдэж буй багш нарын мэдлэг заах арга, ур чадварыг нэмэгдүүлэх хэрэгтэй.

Иймд Монгол Улсын Шинэчлэлийн Засгийн газрын болон аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Боловсрол шинжлэх ухааны яамны "Эрдэм боловсролтой Монгол хүн хөтөлбөр", Монгол Улсын болон аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2014 оны үндсэн чиглэлд дэвшүүлсэн мэдээллийн технологийг сургалтанд нэвтрүүлэх зорилтонд тэргүүлэх ач холбогдол өгч, төсөв хөрөнгө, хүн хүч, цаг хугацаа, техник, технологийн болон удирдлага, зохион байгуулалтын олон талт арга хэмжээ авч хэрэгжүүлэх зорилгоор "Цахим сургууль-Цахим сургалт" хөтөлбөрийг боловсрууллаа.

### **Хоёр. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хамрах хүрээ, хугацаа**

2.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хамрах хүрээ:

Сэлэнгэ аймгийн Ерөнхий боловсролын сургуулиуд

2.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа:

Нэгдүгээр үе шат	2013-2015 оны хичээлийн жил
Хоёрдугаар үе шат	2015-2017 оны хичээлийн жил

### **Гурав. Хөтөлбөрийн зорилго, зорилт:**

3.1 Мэдээлэл, харилцаа холбоо технологийн дэвшлийг ерөнхий боловсролын сургуулиудын өдөр тутмын үйл ажиллагаанд нэвтрүүлэх, багш, суралцагчдын МХХТ-ийг хэрэглэх чадварыг дээшлүүлэх, багш, хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх

3.2. Энэхүү хөтөлбөрийн зорилгыг хангахад дараах зорилтуудыг дэвшүүлж байна.

3.2.1. Нэгдүгээр зорилт: Мэдээлэл, харилцаа холбоо технологийн дэд бүтцийг хөгжүүлэх

3.2.2. Хоёрдугаар зорилт: Боловсролын үйл ажиллагаа, үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, мэдээллийн санг бүрдүүлэх

3.2.3. Гуравдугаар зорилт: Багш нарын мэдээллийн технологийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх

3.2.4. Дөрөвдүгээр зорилт: Мэдээлэл, харилцаа холбоо технологийн мэдлэг, чадвар эзэмшүүлэх сургалтыг суралцагчдын хэрэгцээ, сонирхолд тулгуурлан зохион байгуулж, хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх

### **Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

4.1 Мэдээлэл, харилцаа холбоо технологийн дэд бүтцийг хөгжүүлэх нэгдүгээр зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.1.1 Сургуулиудын хүүхэд, багш нарт ногдох компьютерийн тоог нэмэгдүүлэх, шинэчлэх

4.1.2 Шилэн кабель холбогдсон сумдын сургуулиудыг интернэтэд холбох, бусад сургуулиудад WiFi сүлжээ байгуулах

4.1.3 Мэдээллийн технологийг сургалтад ашиглах болон цахим сургалтын материал бэлтгэхэд нь зориулан сургууль бүрийг МХХТ-ийн иж бүрэн техник хэрэгслээр хангах ажлыг үргэлжлүүлэн МХХТ-ийг кабинетуудыг байгуулах.

байгуулж байгаа ба 23 ерөнхий боловсролын сургууль өөрийн нөөц бололцоог ашиглан үүрэн холбооны операторын модем ашиглаж интернетийн хэрэглээгээ авч байна.

Мэдээлэл харилцааны эрин зуунд манай хүүхдүүд бусад орны үе тэнгийнхнээс хоцролгүй мэдээлэл авах, мэдээлэлтэй харилцах арга ухаанд суралцах шаардлагатай гарч байна. Иймд тэднийг бэлдэж буй багш нарын мэдлэг заах арга, ур чадварыг нэмэгдүүлэх хэрэгтэй.

Иймд Монгол Улсын Шинэчлэлийн Засгийн газрын болон аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Боловсрол шинжлэх ухааны яамны "Эрдэм боловсролтой Монгол хүн хөтөлбөр", Монгол Улсын болон аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2014 оны үндсэн чиглэлд дэвшүүлсэн мэдээллийн технологийг сургалтанд нэвтрүүлэх зорилтонд тэргүүлэх ач холбогдол өгч, төсөв хөрөнгө, хүн хүч, цаг хугацаа, техник, технологийн болон удирдлага, зохион байгуулалтын олон талт арга хэмжээ авч хэрэгжүүлэх зорилгоор "Цахим сургууль-Цахим сургалт" хөтөлбөрийг боловсрууллаа.

### **Хоёр. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хамрах хүрээ, хугацаа**

#### 2.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хамрах хүрээ:

Сэлэнгэ аймгийн Ерөнхий боловсролын сургуулиуд

#### 2.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа:

Нэгдүгээр үе шат	2013-2015 оны хичээлийн жил
Хоёрдугаар үе шат	2015-2017 оны хичээлийн жил

### **Гурав. Хөтөлбөрийн зорилго, зорилт:**

3.1 Мэдээлэл, харилцаа холбоо технологийн дэвшлийг ерөнхий боловсролын сургуулиудын өдөр тутмын үйл ажиллагаанд нэвтрүүлэх, багш, суралцагчдын МХХТ-ийг хэрэглэх чадварыг дээшлүүлэх, багш, хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх

3.2. Энэхүү хөтөлбөрийн зорилгыг хангахад дараах зорилтуудыг дэвшүүлж байна.

3.2.1. Нэгдүгээр зорилт: Мэдээлэл, харилцаа холбоо технологийн дэд бүтцийг хөгжүүлэх

3.2.2. Хоёрдугаар зорилт: Боловсролын үйл ажиллагаа, үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, мэдээллийн санг бүрдүүлэх

3.2.3. Гуравдугаар зорилт: Багш нарын мэдээллийн технологийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх

3.2.4. Дөрөвдүгээр зорилт: Мэдээлэл, харилцаа холбоо технологийн мэдлэг, чадвар эзэмшүүлэх сургалтыг суралцагчдын хэрэгцээ, сонирхолд тулгуурлан зохион байгуулж, хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх

### **Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

4.1 Мэдээлэл, харилцаа холбоо технологийн дэд бүтцийг хөгжүүлэх нэгдүгээр зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.1.1 Сургуулиудын хүүхэд, багш нарт ногдох компьютерийн тоог нэмэгдүүлэх, шинэчлэх

4.1.2 Шилэн кабель холбогдсон сумдын сургуулиудыг интернэтэд холбох, бусад сургуулиудад WiFi сүлжээ байгуулах

4.1.3 Мэдээллийн технологийг сургалтад ашиглах болон цахим сургалтын материал бэлтгэхэд нь зориулан сургууль бүрийг МХХТ-ийн иж бүрэн техник хэрэгслээр хангах ажлыг үргэлжлүүлэн МХХТ-ийг кабинетуудыг байгуулах.

**Зургаа. Хөтөлбөрийн зорилтийг хэрэгжүүлэх арга зам, үйл ажиллагаа**

<b>“Цахим сургууль-Цахим сургалт” аймгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зам, үйл ажиллагаа</b>						
№	Үйл ажиллагаа	БШУЯ	Аймгийн ИТХ, ЗДТГ, Сумдын ИТХ, ЗДТГ	Боловсролын газар	Ерөнхий боловсролын сургууль	
<b>Нэг. Мэдээллийн технологийн дэд бүтцийг хөгжүүлэх зорилтын хүрээнд:</b>						
1.1	Сургуулиудын хүүхэд, багш нарт ногдох компьютерийн тоог нэмэгдүүлэх, шинэчлэх	"Нэг хүүхэд нэг компьютер", "Багш бүрт нэг компьютер" төслийг хэрэгжүүлэх	Шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсвийн төсөлд тусгах, хөрөнгөөр санхүүжүүлэх арга хэмжээ авах. /интернэтэд холбох, WiFi сүлжээ байгуулах тавилтын зардлыг гаргах боломжийг судлах /	Сургуулиудын компьютер, техник хангамжийн судалгаа гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлэх, интернэтэд холбогдсон сургуулиудын суваг ашиглах зардлыг хуваарилах	Компьютер, техник хангамжийн судалгааг үндэслэн компьютероо нэмэгдүүлэх, шинэчлэх асуудлыг шийдвэрлэнэ.	
1.2	Шилэн кабель холбогдсон сумдын сургуулиудыг интернэтэд холбох, бусад сургуулиудад WiFi сүлжээ байгуулах	Хуваарийн дагуу зарим сургуулиудыг интернэтэд холбох		/Интернэтэд холбогдсон сургуулиудын урсгал зардлын төсвийг нэмэгдүүлэх саналыг БШУЯнд хүргүүлэх /	Сум, орон нутгийн нөөц бололцоог ашиглан сургуульдаа интернэт тавиулах, анги танхимуудаа дотоод сүлжээнд холбуулах ажлыг шат дараатай хийх	
1.3	Мэдээллийн технологийг сургалтад ашиглах болон цахим сургалтын материал бэлтгэхэд нь зориулан сургууль бүрийг МХХТ-ийн иж бүрэн техник хэрэгслээр хангах ажлыг үргэлжлүүлэн МХХТ-ийг кабинетуудыг байгуулах.	Хуваарийн дагуу зарим сургуулиудад мэдээллийн технологийн танхим өгөх				Сум, орон нутагт хэрэгжиж байгаа олон улсын төсөл хөтөлбөрт хамрагдаж, мэдээлэл зүйн кабинетуудыг МХХТ-ийн иж бүрэн техник хэрэгслээр хангах ажлыг үргэлжлүүлэх
1.4	Сургуулийн бүх багш нарыг сургалтандаа зөөврийн компьютер ашиглах боломжийг бүрдүүлсэн байх	"Багш бүрт нэг компьютер" төслийг хэрэгжүүлэх		Хувьдаа зөөврийн компьютер авах хүсэлтэй багш нарт санхүүгийн боломж олгоход туслах	"Багш бүрт нэг компьютер" төсөлд хамрагдаагүй сургуулиудын судалгааг нэгтгэн дээд шатны байгууллагад	Багш нарыг сургалтандаа зөөврийн компьютер ашиглах орчин нөхцөлийг бүрдүүлсэн байх

**Зургаа. Хөтөлбөрийн зорилтийг хэрэгжүүлэх арга зам, үйл ажиллагаа**

<b>“Цахим сургууль-Цахим сургалт” аймгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зам, үйл ажиллагаа</b>						
№	Үйл ажиллагаа	БШУЯ	Аймгийн ИТХ, ЗДТГ, Сумдын ИТХ, ЗДТГ	Боловсролын газар	Ерөнхий боловсролын сургууль	
<b>Нэг. Мэдээллийн технологийн дэд бүтцийг хөгжүүлэх зорилтын хүрээнд:</b>						
1.1	Сургуулиудын хүүхэд, багш нарт ногдох компьютерийн тоог нэмэгдүүлэх, шинэчлэх	"Нэг хүүхэд нэг компьютер", "Багш бүрт нэг компьютер" төслийг хэрэгжүүлэх	Шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсвийн төсөлд тусгах, хөрөнгөөр санхүүжүүлэх арга хэмжээ авах. /интернэтэд холбох, WiFi сүлжээ байгуулах тавилтын зардлыг гаргах боломжийг судлах /	Сургуулиудын компьютер, техник хангамжийн судалгаа гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлэх, интернэтэд холбогдсон сургуулиудын суваг ашиглах зардлыг хуваарилах	Компьютер, техник хангамжийн судалгааг үндэслэн компьютероо нэмэгдүүлэх, шинэчлэх асуудлыг шийдвэрлэнэ.	
1.2	Шилэн кабель холбогдсон сумдын сургуулиудыг интернэтэд холбох, бусад сургуулиудад WiFi сүлжээ байгуулах	Хуваарийн дагуу зарим сургуулиудыг интернэтэд холбох		/Интернэтэд холбох, WiFi сүлжээ байгуулах тавилтын зардлыг гаргах боломжийг судлах /	Сум, орон нутгийн нөөц бололцоог ашиглан сургуульдаа интернэт тавиулах, анги танхимуудаа дотоод сүлжээнд холбуулах ажлыг шат дараатай хийх	
1.3	Мэдээллийн технологийг сургалтад ашиглах болон цахим сургалтын материал бэлтгэхэд нь зориулан сургууль бүрийг МХХТ-ийн иж бүрэн техник хэрэгслээр хангах ажлыг үргэлжлүүлэн МХХТ-ийг кабинетуудыг байгуулах.	Хуваарийн дагуу зарим сургуулиудад мэдээллийн технологийн танхим өгөх			/Интернэтэд холбогдсон сургуулиудын урсгал зардлын төсвийг нэмэгдүүлэх саналыг БШУЯнд хүргүүлэх /	Сум, орон нутагт хэрэгжиж байгаа олон улсын төсөл хөтөлбөрт хамрагдаж, мэдээлэл зүйн кабинетуудыг МХХТ-ийн иж бүрэн техник хэрэгслээр хангах ажлыг үргэлжлүүлэх
1.4	Сургуулийн бүх багш нарыг сургалтандаа зөөврийн компьютер ашиглах боломжийг бүрдүүлсэн байх	"Багш бүрт нэг компьютер" төслийг хэрэгжүүлэх		Хувьдаа зөөврийн компьютер авах хүсэлтэй багш нарт санхүүгийн боломж олгоход туслах	"Багш бүрт нэг компьютер" төсөлд хамрагдаагүй сургуулиудын судалгааг нэгтгэн дээд шатны байгууллагад	Багш нарыг сургалтандаа зөөврийн компьютер ашиглах орчин нөхцөлийг бүрдүүлсэн байх

				хүргүүлэх	
1.5	Сургууль бүр цахим хуудастай болох		Цахим хуудастай болох зардлыг төсөвт тусгах	Сургууль бүрийг цахим хуудастай болгох сургалтыг зохион байгуулах	Сургууль бүр өөрийн сургуулийн онцлогт тохирсон цахим хуудастай болох
1.6	Багш нарыг мэдээллийн технологи ашиглах арга зүйд сургах, ном, гарын авлага, материалаар хангах	Мэдээллийн технологийн ном, гарын авлага, программуудыг боловсруулах	Мэдээллийн технологийн ном, гарын авлагын санхүүгийн асуудлыг шийдвэрлэхэд туслах	Багш нарыг мэдээллийн технологи ашиглах арга зүйд сургах, ном, гарын авлага, материалаар хангах, тэдгээрийг хэрхэн ашиглах талаар сургалт зохион байгуулах	Ном, гарын авлага, программуудыг сургалтандаа хэрэглэх
1.7	Цахим номын сангуудыг шаттайгаар сургуулиудад байгуулах ажлыг үргэлжлүүлэх		Цахим номын сан байгуулахад шаардагдах хөрөнгөд дэмжлэг үзүүлэх	Цахим номын сан байгуулахад дэмжлэг үзүүлэх, сургалт зохион байгуулах	Цахим номын байгуулж, үйл ажиллагааг жигдрүүлэх
1.8	Мэдээлэл харилцаа технологийг нэвтрүүлсэн загвар цахим сургууль бий болохыг бүх талаар дэмжих, цахим сургуулийн тоог нэмэгдүүлэх	Цахим сургуулийн хөрөнгийг нийлүүлэх мэдээллийн технологийн компанийг шалгаруулах	Улсын тэргүүний сумын сургууль болоход үзүүлэх	Баянгол цахим дэмжлэг	Цахим сургууль болоход шаардагдах материал, нөхцлийг бүрдүүлэх
<b>Хоёр. Боловсролын үйл ажиллагаа, үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, мэдээллийн санг бүрдүүлэх зорилтын хүрээнд</b>					
2.1	Багш, сурагчдын нэгдсэн мэдээллийн сан бий болгох.	“Боловсролын удирдлагын мэдээллийн систем” нэвтрүүлэх		Багш, сурагчдын нэгдсэн мэдээллийн санг шинэчилэх, баяжуулах	Багш, сурагчдын мэдээллүүдийг нэгтгэн сургуулийн сантай болгох.
2.2	Багш нарын шилдэг хичээлийн санг бүрдүүлэх,			Багш нарын шилдэг хичээлийн	Сургуулийн боловсролын технологийн

	интернетэд байршуулах, сурталчилах.			санг бүрдүүлэх, интернетэд байршуулах, сурталчилах, боловсролын технологийн хөгжлийн сантай болох	хөгжлийн санг бүрдүүлэх, багш нарын дунд ур чадварын уралдааныг зохион байгуулж шилдэг хичээлийг шалгаруулах,
<b>Гурав. Багш нарын мэдээллийн технологийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилтын хүрээнд:</b>					
3.1	Багшийн хөгжлийн төвийг багш нарт зориулсан мэдээллийн технологийн сургалтын төв болгон ашиглах өргөжүүлэх. Багш нарын мэдээллийн технологийн ур чадварыг дээшлүүлэх.		Багшийн хөгжлийн төвийг	Багшийн хөгжлийн төвийг багш нарт зориулсан мэдээллийн технологийн сургалтын төв болгон ашиглах өргөжүүлэх. Багш нарын мэдээллийн технологийн ур чадварыг дээшлүүлэх.	Багшийн хөгжлийн төвийг багш нарт зориулсан мэдээллийн технологийн сургалтын төв болгон ашиглах өргөжүүлэх. Багш нарын мэдээллийн технологийн ур чадварыг дээшлүүлэх.
3.2	Багш болон удирдах ажилтнуудад зориулсан цахим сургалтуудыг үе шаттайгаар зохион байгуулах			Багш болон удирдах ажилтнуудад зориулсан цахим сургалтуудыг үе шаттайгаар зохион байгуулах	Багш болон удирдах ажилтнуудад зориулсан цахим сургалтуудыг үе шаттайгаар зохион байгуулах
3.3	Багш нарын ажил мэргэжлийн уралдаан тэмцээнийг цахим хэлбэрээр явуулах.		Уралдаан тэмцээнд амжилттай оролцсон багш нарыг урамшуулах, шагнах зардлыг гаргах	Багш нарын ажил мэргэжлийн уралдаан тэмцээнийг цахим хэлбэрээр үе шаттай явуулах удирдамж боловсруулан сургуулиудад хүргүүлэх	Удирдамжийн дагуу цахим хэлбэрээр багш нарын дунд уралдаан тэмцээнээ зохиох
3.4	Цахим болон видео хичээл бэлтгэх арга зүйд сургах, зөвлөн туслах			Цахим болон видео хичээл бэлтгэх арга зүйд сургах	Багш нар цахим болон видео хичээл бэлтгэх хичээл заах



				сургалт зохион байгуулах, зөвлөмж хүргүүлэх	
<b>Дөрөв.Мэдээлэл, харилцаа холбоо технологийн мэдлэг, чадвар эзэмшүүлэх сургалтыг суралцагчдын хэрэгцээ, сонирхолд тулгуурлан зохион байгуулж, хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх зорилтын хүрээнд:</b>					
4.1	Багш интернэт, электрон шууданг ашиглан, шаардлагатай мэдээллээ бэлтгэн хүүхэд бүрийг хөгжүүлэхэд чиглэсэн сургалтыг зохион байгуулах			Багш нарт цахим хичээл, цахим хэрэглэгдэхүү н бэлтгэж хичээл заах сургалтыг зохион байгуулах	Суралцагчдын хэрэгцээ, сонирхолд тулгуурлан хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх сургалтыг мэдээлэл, харилцаа холбоо технологийг ашиглан заах
4.2	Суралцагчдын хэрэгцээ, сонирхолд тулгуурлан орчин үеийн хэрэглээний программуудыг ашиглан мэдээлэл, харилцаа холбоо технологийн__мэдлэг, чадвар, дадлыг эзэмшүүлэх сургалт, уралдаан тэмцээнийг тогтмол зохион байгуулах		Уралдаан тэмцээнд амжилттай оролцсон сурагчдыг урамшуулах, шагнах зардлыг гаргах	Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд мэдээллийн технологийн чиглэлээр илтгэлийн уралдаан зохион байгуулах	Мэдээлэл, харилцаа холбоо технологийн мэдлэг, чадвар эзэмшүүлэх сургалт, уралдааныг сурагчдын дунд зохион байгуулах,

#### Долоо. Хөтөлбөрийн санхүүжилт

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ.

7.1 Улсын төсвийн хөрөнгө

7.2 Орон нутгийн төсвийн хөрөнгө

7.3 Хандивлагч орон, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгө

7.4 Олон улсын байгууллагын банк, санхүүгийн байгууллагын зээл, тусламжийн хөрөнгө

7.5 Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт

7.6 Бусад

#### Найм. Хөтөлбөрийг хэрэгжүүлсэнээр хүрэх үр дүн

Хөтөлбөрийг хэрэгжүүлсэнээр дараах үр дүнд хүрнэ.

### 8.1 Сургуулийн хувьд:

8.1.1 Сургуулийн үйл ажиллагаанд оролцох иргэд, олон нийт, эцэг эх, асран хамгаалагчдын тоо нэмэгдэнэ.

8.1.2 Сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байж, хяналт сайжирна.

8.1.3 Багш сурагчдын нэгдсэн мэдээллийн сантай болно.

8.1.4 Цаасгүй технологи ашигласнаар зардал мөнгө хэмнэх, мэдээ мэдээллийг цаг алдалгүй түгээдэг болно.

### 8.2 Багш нарын хувьд:

8.2.1 Сурагчдынхаа сурлагын амжилтанд дүн шинжилгээ хийж, өөрийн хичээл заадаг ангиудын амжилтыг харьцуулан шинжилж дүгнэлт гаргадаг.

8.2.2 Сургалт, үйл ажиллагааны талаарх судалгааг сурагч болон эцэг эхээс авч on-line-аар холбогдон үйл ажиллагаагаа ойртуулдаг болно.

8.2.3 Сургалтын үйл ажиллагаандаа мэдээлэл технологийн шинэчлэлийг ашиглах боломжтой болно.

### 8.3 Суралцагчдын хувьд:

8.3.1 Шинэ мэдлэг олж авна.

8.3.2 Мэдээллийн технологийн мэдлэгээ сайжруулах, цахим сүлжээг ашиглах, хэрэглэх чадвартай болно.

“ЦАХИМ СУРГУУЛЬ – ЦАХИМ СУРГАЛТ” АЙМГИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮН / тоо,хувь /					
№	Үйл ажиллагаа	2014 он	2015 он	2016 он	2017 он
<b>Нэг. Мэдээллийн технологийн дэд бүтцийг хөгжүүлэх зорилтын хүрээнд:</b>					
	Сургуулиудын хүүхэд, багш нарт ногдох компьютерийн тоог нэмэгдүүлэх, шинэчлэх	Нэг компьютерт ногдох хүүхдийн тоог дунджаар 29 – д хүргэнэ	28	26	25
		Нэг компьютерт ногдох багшийн тоог дунджаар 3 –д хүргэнэ	2,5	2	1
	Шилэн кабель холбогдсон сумдын сургуулиудыг интернэтэд холбох, бусад сургуулиудад WiFi сүлжээ байгуулах	15 сургууль буюу 42,8%- нь шилэн кабелиар интернэтэд холбогдсон байна.	18 буюу 51,4%	20 буюу 57,1%	25 буюу 71,4%
	Мэдээллийн технологийг сургалтад ашиглах болон цахим сургалтын материал бэлтгэхэд нь зориулан сургууль	Мэдээллийн технологийн кабинетуудыг LCD телевизор, проектор, сканнер, принтер, хувилагч, дэлгэц, дижитал зургийн аппарат, DVD-бичигч, электрон самбар зэрэг МХТ-ийн үндсэн хэрэгслээр шинэчилж, баяжуулнаар. мэдээллийн технологийг сургалтад ашиглах болон цахим сургалтын			

бүрийг МХХТ-ийн иж бүрэн техник хэрэгслээр хангах ажлыг үргэлжлүүлэн МХХТ-ийг кабинетуудыг байгуулах.	материал бэлтгэх нөхцөл бүрдэнэ.			
Сургуулийн бүх багш нарыг сургалтандаа зөөврийн компьютер ашиглах боломжийг бүрдүүлсэн байх	33%	40%	50%	60%
Сургууль бүр цахим хуудастай болох	20%	25%	30%	50%
Багш нарыг мэдээллийн технологи ашиглах арга зүйд сургах, ном, гарын авлага, материалаар хангах	Ном, гарын авлага, зөвлөмж, материалаар багш нарыг хангаснаар тэд суралцагчдын хэрэгцээ, сонирхолд нийцсэн, хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх сургалтыг мэдээлэл, харилцаа холбоо технологийг ашиглан заах эхлэл тавигдана.			
Цахим номын сангуудыг үе шаттайгаар сургуулиудад байгуулах ажлыг үргэлжлүүлэх	6	8	9	10
Мэдээлэл харилцаа технологийг нэвтрүүлсэн загвар цахим сургууль бий болохыг бүх талаар дэмжих, цахим сургуулийн тоог нэмэгдүүлэх	1	1	2	2
<b>Хоёр. Боловсролын үйл ажиллагаа, үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, мэдээллийн санг бүрдүүлэх зорилтын хүрээнд:</b>				
Багш, сурагчдын нэгдсэн мэдээллийн сан бий болгох.	Багш, сурагчдын нэгдсэн мэдээллийн санг шинэчилэн, баяжуулснаар боловсролын үйл ажиллагаа, үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх нөхцөл бүрдэнэ			
Багш нарын шилдэг хичээлийн санг бүрдүүлэх, интернетэд байршуулах, сурталчилах.	18	90	150	200
<b>Гурав. Багш нарын мэдээллийн технологийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилтын хүрээнд:</b>				
Багшийн хөгжлийн төвийг багш нарт зориулсан мэдээллийн технологийн сургалтын төв болгон ашиглах өргөжүүлэх. Багш нарын мэдээллийн технологийн ур чадварыг дээшлүүлэх.	"Багшийн хөгжлийн төв"өөр дамжуулан багш нар ажлын байрандаа мэргэжлээ дээшлүүлж, боловсролын шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх сургалтын үйл ажиллагаандаа мэдээллийн технологийн өнөөгийн хэрэгцээнд нийцүүлэн МХТ-ийг үр дүнтэй ашиглаж, сургалтын цахим хэрэглэгдэхүүнээ боловсруулах нөхцөл бүрдэнэ.			
Багш болон удирдах ажилтнуудад зориулсан цахим сургалтуудыг үе	2	3	3	3

шаттайгаар зохион байгуулах				
Багш нарын ажил мэргэжлийн уралдаан тэмцээнийг цахим хэлбэрээр явуулах.	1	1	1	1
Цахим болон видео хичээл бэлтгэх	33	70	120	180
<b>Дөрөв. Мэдээлэл, харилцаа холбоо технологийн мэдлэг, чадвар эзэмшүүлэх сургалтыг суралцагчдын хэрэгцээ, сонирхолд тулгуурлан зохион байгуулж, хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх зорилтын хүрээнд:</b>				
Багш интернэт, электрон шууданг ашиглан, шаардлагатай мэдээллээ бэлтгэн хүүхэд бүрийг хөгжүүлэхэд чиглэсэн сургалтыг зохион байгуулах	Ухаалаг самбар, мультмедиа материал, компьютерийн лаборатори ашиглан хичээл заадаг багшийн тоо жил бүр нэмэгдэнэ.			
Суралцагчдын хэрэгцээ, сонирхолд тулгуурлан орчин үеийн хэрэглээний программуудыг ашиглан мэдээлэл, харилцаа холбоо технологийн мэдлэг, чадвар, дадлыг эзэмшүүлэх сургалт, уралдаан тэмцээнийг тогтмол зохион байгуулах	Жил бүр ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд мэдээллийн технологийн чиглэлээр илтгэлийн уралдааныг зохион байгуулснаар бүтээлийн уралдаанд оролцох боломтой болно.			

**Ёс. “Цахим сургууль-Цахим сургалт” аймгийн хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт- шинжилгээ хийж, үнэлгээ өгөх шалгуур үзүүлэлтүүд**

Аймгийн хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд хяналт шинжлэгээ хийж, үнэлгээ өгөхдөө энэхүү шалгуур үзүүлэлтийг баримтална.

Зорилт	Шалгуур үзүүлэлт	Тоо	Хувь	Тайлбар
Мэдээлэл, харилцаа холбоотехнологийн дэд бүтцийг хөгжүүлэх	ЕБС-д компьютер хэрэглэдэг суралцагчийн тоо ба компьютерийн тооны харьцаа			
	Сургалтандаа зөөврийн компьютер ашигладаг багшийн тоо, хувь			
	Шилэн кабелиар интернэтэд холбогдсон сургуулийн тоо, хувь			
	МХТ-ийн үндсэн хэрэгслээр тоноглогдсон кабинетийн тоо, хувь			
	Цахим хуудастай сургуулийн тоо, хувь			

	Цахим номын сантай сургуулийн тоо, хувь			
	Цахим сургуулийн тоо, хувь			
Боловсролын үйл ажиллагаа, үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, мэдээллийн санг бүрдүүлэх	Боловсролын технологийн хөгжлийн сантай сургуулийн тоо, хувь			
	Багш нарын шилдэг хичээлийн сан бүрдүүлсэн сургуулийн тоо хувь			
	Цахим болон видео хичээл бэлтгэсэн багшийн тоо, хувь			
Багш нарын мэдээллийн технологийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх	Мэдээллийн технологийн сургалтанд хамрагдсан удирдах ажилтан, багшийн тоо, хувь			
	Хувийн блог ажиллуулдаг багшийн тоо, хувь			
	Мэргэжлийн мэдээлэл зүйн багшийн тоо, хувь			
Мэдээлэл, харилцаа холбоо технологийн мэдлэг, чадвар эзэмшүүлэх сургалтыг суралцагчдын хэрэгцээ, сонирхолд тулгуурлан зохион байгуулж, хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх	Ухаалаг самбар ашиглаж хичээл заасан багшийн тоо, хувь			
	Мультимедиа материал ашиглаж хичээл заасан багшийн тоо, хувь			
	Компьютерийн лаборатори ашиглан хичээл заасан багшийн тоо, хувь			
	Сурагчдад зориулсан мэдээллийн технологийн чадвар эзэмшүүлэх сургалтын тоо / сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнөөс гадна/			
	Сурагчдын дунд зохион байгуулсан уралдаан тэмцээний тоо			

### **Арав. Удирдлага, хяналт-шинжилгээ, үнэлгээ, тайлан гаргах**

10.1 Боловсролын газар нь “Цахим сургууль-цахим сургалт” аймгийн хөтөлбөрийг стратегийн удирдлага, төлөвлөлтөөр хангах, бодлогын хэрэгжилтийг зохицуулах, хяналт тавин үнэлгээ хийж, хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагаатай уялдуулан зохицуулна.

10.2 Ерөнхий боловсролын сургууль нь “Цахим сургууль-цахим сургалт” аймгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган ажиллаж, тайланг жил бүрийн 12 сарын 20, 6 сарын 10 ны дотор Боловсролын газарт ирүүлнэ.

10.3 Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын талаар хөтөлбөрийн баг Боловсролын газрын зөвлөлийн хуралд жилд нэг удаа танилцуулж дүгнэлт гаргуулна.

10.4 Боловсролын газар нь хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жилийн эцэст аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ.

## Арван нэг: Хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад гарах эрсдэл

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад дараах эрсдлүүд гарч болзошгүй

- Монгол улсын засгийн газраас хэрэгжүүлж буй "Хүүхэд бүрт компьютер" , "Багш бүрт нэг компьютер " хөтөлбөр санхүүжүүлэлтээс хамаарч удаан хэрэгжиж байгаа тул энэ хөтөлбөрийн 4.1.1 дэх заалт сургуулиудын хүүхэд, багш нарт ногдох компьютерийн тоог нэмэгдүүлэх, шинэчлэх ажил удаашрах магадлалтай .
- Шилэн кабель, WiFi сүлжээний тоног төхөөрөмжийг суурилуулсны дараа сургуулиудад хуваарилагдаж ирдэг урсгал зардлын / холбооны шугам ашиглалтын зардлын / төсөв бага, хүрэлцдэггүй тул заримдаа төлбөрөө төлөөгүйгээс интернэтээ салгуулах тохиолдол гарч багш нар интернэт, электрон шууданг ашиглан, шаардлагатай мэдээллээ бэлтгэн хүүхэд бүрийг хөгжүүлэхэд чиглэсэн сургалтыг зохион байгуулах, багш нарын шилдэг хичээлийн санг бүрдүүлэх, интернетэд байршуулах, сурталчилах, тэдэнд зориулсан цахим сургалтуудыг үе шаттайгаар зохион байгуулж чадахгүйд хүрнэ.
- Тухайн орон нутгийн төсөвт хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад шаардагдах МТ-ийн техник хэрэгслийн зардлыг тухайн жилд тусгаагүй бол хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломжгүй болж багш цахим сургалтын материал бэлтгэх, суралцагчдын хэрэгцээ, сонирхолд тулгуурлан орчин үеийн хэрэглээний программуудыг ашиглан мэдээлэл, харилцаа холбоо технологийн мэдлэг, чадвар, дадлыг эзэмшүүлэх сургалтаа явуулах боломжгүй болно.